



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 02 сарын 17 өдөр

Дугаар 4/51

Хэрлэн сум

Салбар комисс байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2, 37.5, Засгийн газрын 2016 оны 200 дугаар тогтоолоор баталсан Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын дүрмийн 1 дүгээр зүйлийн 1.2, 2.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аймгийн хэмжээнд 0-16 насны хүүхэд хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тогтоох, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамруулах үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хэрэгжилтэд хяналт тавих зорилго бүхий комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга:	Г.Лхагвахатан	-Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга:	Б.Нандинцэцэг	-Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын мэргэжилтэн
Гишүүд :	Х.Болоргэрэл	-Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн
	Х.Уртнасан	-Гэр бүл хүүхэд залуучуудын газрын мэргэжилтэн
	Л.Эрдэнэсүвд	-Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн их эмч
	О.Намжилмаа	-Нэгдсэн эмнэлгийн мэдрэлийн их эмч
	Г.Хатанбаатар	-Нэгдсэн эмнэлгийн их эмч

Хоёр. Орон нутгийн салбар комиссын үйл ажиллагааг тогтмолжуулж чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахыг Комиссын дарга Г.Лхагвахатанд үүрэг болгосугай.

Гурав. Засгийн газрын 2016 оны 200 дугаар тогтоолоор Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын дүрэм батлагдан гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2014 оны А/538 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

01 325